

Үндэсний статистикийн газрын даргын  
200.. оны ... дугаар сарын ... – ны өдрийн  
.....тоот тушаалын хавсралт

## Дотоодын нийт бүтээгдэхүүнийг улирлаар тооцох аргачлал

2008 он

## **Дотоодын нийт бүтээгдэхүүнийг улирлаар тооцох аргачлал**

### Гарчиг

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, оны үнээр тооцох аргачлал

Гурав. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал

Дөрөв. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эцсийн ашиглалтын аргаар, улирлаар тооцох аргачлал

Хавсралт 1. Бенч программ, түүний ашиглалт

Хавсралт 2. Улирлын тооцоонд ашиглах мэдээлэл

## ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)-ИЙГ УЛИРЛААР ТООЦОХ АРГАЧЛАЛ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг улирлаар тооцох аргачлал нь Үндэсний статистикийн газар (ҮСГ)-ын дарга, Сангийн сайдын 2007 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 101/203 тоот тушаалаар батласан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-ын зарчимд үндэслэгдэнэ.

ДНБ-ийг улирлаар тооцох нь дараахь давуу талтай. Үүнд:

- Эдийн засгийн хөгжлийн түвшинг богино хугацаанд тодорхойлж, бизнесийн мөчлөг (цикл)-т судалгаа, шинжилгээ хийх, эдийн засгийн бодлогыг богино хугацаанд хэрэгжүүлэх, эконометрик загварчлалд ашиглах суурь мэдээллийг бий болгох, мэдээллийн чанарт хяналт тавих;
- Нийгэм, эдийн засгийн жилийн урьдчилсан төлөв байдлыг богино хугацаатайгаар тооцож тодорхойлох;
- Эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын динамик холбоог илүү харуулах эдгээр болно.

ДНБ-ий улирлын тооцоо нь жилийн тооцоотой харилцан уялдана. ДНБ-ийг улирлаар тооцох нь улирлын мэдээллийн эх үүсвэрийн боломжоос ихээхэн шалтгаална. ДНБ-ий улирлын тооцоонд жилийн тооцооны үзүүлэлтүүд, салбарын богино хугацааны шалгуур үзүүлэлтүүд ашиглагдана.

ДНБ-ий улирлын тооцооны боловсруулалтыг 2 үе шатаар хийнэ.

- бэлтгэл үе шат
- боловсруулалтын үе шат

Бэлтгэл үе шатанд өнгөрсөн хугацааны шаардлагатай мэдээллийг тооцож, урьдчилан бэлтгэнэ. Өмнөх онуудын мэдээллийг бэлтгэх нь уг мэдээллийг дахин шалгах, мэдээллийн хандлагыг судалж, тооцоог бодитой болгох ач холбогдолтой.

Боловсруулалтын үе шатанд тайлант хугацааны улирлын мэдээллийг боловсруулж, динамик үзүүлэлт дээр үндэслэн тооцсон улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг жилийн жинхэнэ гүйцэтгэлтэй уялдуулан шинэчилнэ.

ДНБ-ийг улирлаар тооцоход дараахь нийтлэг үндэслэлийг баримтлана.

1. Улирлын тооцоонд тухайн салбарын жилийн үйл ажиллагааны улирлын өөрчлөлтийг харуулж чадах богино хугацааны шалгуур үзүүлэлтийг ашиглан, тэдгээрийн өсөлт, бууралтын хандлагаар салбарын нэмэгдэл өртгийг тооцно.

Улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцохдоо улирлын үндсэн үзүүлэлтийн хэмжээг өмнөх оны улирлын нэмэгдэл өртөг болон салбарын үндсэн үзүүлэлтийн<sup>1</sup> харьцаагаар үржүүлж тооцно. Үүнд дараахь томъёог ашиглана.

---

<sup>1</sup> Салбарын үндсэн үзүүлэлтийг Хавсралт2-оос үзэх.

$$X_{q,\beta+1} = I_{q,\beta+1} * \left( \frac{X_{4,\beta}}{I_{4,\beta}} \right) \quad (1)$$

$\left( \frac{X_{4,\beta}}{I_{4,\beta}} \right)$  - нэмэгдэл өртөг үндсэн үзүүлэлтийн харьцаа (цаашид нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн BI харьцаа гэх)

$X$  – нэмэгдэл өртгийн хэмжээ

$I$  – салбарын үндсэн үзүүлэлтийн хэмжээ

$q$  - улирал

$\beta+1$  – тайлант он

$\beta$  – тайлант оны өмнөх жил

Жишээ нь, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн хэмжээ 2005, 2006 оноор, улирлаар өгөгдсөн байна (Хүснэгт1). 2007 оны 1 дүгээр улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцохдоо тухайн улирлын үндсэн үзүүлэлтийн гүйцэтгэлийг 2006 оны 4 дүгээр улирлын нэмэгдэл өртөг, үндсэн үзүүлэлтийн харьцаагаар үржүүлж тооцно.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн хэмжээ, улирлаар, тэрбум төгрөгөөр

А	Үндсэн үзүүлэлт (Нийт үйлдвэрлэлт)	Улирлын нэмэгдэл өртөг	BI харьцаа 3=2/1
	1	2	
2005- I	187.0	122.3	0.654
2005- II	243.9	158.4	0.649
2005 – III	278.9	181.2	0.650
2005- IV	223.1	146.4	0.656
<b>Дүн</b>	<b>932.9</b>	<b>608.2</b>	
2006-I	181.7	121.0	0.666
2006-II	222.7	150.1	0.674
2006-III	231.0	156.9	0.679
2006-IV	320.4	218.2	<b>0.681</b>
<b>Дүн</b>	<b>955.8</b>	<b>646.3</b>	
2007-I	200.3	136.4	<b>0.681</b>
2007-II	243.1	165.6	<b>0.681</b>
2007-III	230.7	157.1	<b>0.681</b>

Дээрх жишээнээс харахад хамгийн сүүлийн жинхэнэ гүйцэтгэлийн тооцоо буюу 2006 оны 4 дүгээр улирлын байдлаар аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн BI харьцаа 0.681 байна. Тайлант улиралд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн хэмжээ болон дээрх харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно. Тухайлбал, нийт үйлдвэрлэлтийн хэмжээ 2007 оны 1 дүгээр улиралд 200.3 тэрбум төгрөг, үүнийг нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн харьцаа болох 0.681 коэффициентээр үржүүлж, салбарын улирлын нэмэгдэл өртгийн хэмжээ буюу 136.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг олно.

Богино хугацааны үндсэн үзүүлэлт тооцдог бүх салбарын хувьд салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо дээрх аргыг ашиглана. Иймд салбар тус бүр дээр тухайн салбарын үйл ажиллагааг төлөөлж чадах улирлын үндсэн үзүүлэлтийг тооцоонд ашиглана.

2. Улирлын дүнгээр тооцсон ДНБ-ий хэмжээ жилийн жинхэнэ гүйцэтгэлтэй тэнцэх ёстой. Иймээс улирлаар тооцсон салбаруудын нэмэгдэл өртгийн гүйцэтгэлийг жилийн эцсийн жинхэнэ гүйцэтгэлээр засварлана. Улирлын болон жилийн гүйцэтгэлийн уялдаа холбоо хэр сайн байх нь улирлын мэдээллийн чанараас шууд шалтгаална. Сар, улирлын мэдээллүүд нь гол төлөв богино хугацаанд урьдчилсан гүйцэтгэлээр гарна. Салбаруудын мэдээллийг тодотгож засварласан тохиолдолд ДНБ-ий улирлын тооцоог мөн тодотгож засварлана.
3. Улс орны онцлогоос хамаарч, эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа нь улирлын хэлбэлзэлтэй байж болно. ДНБ-ий улирлын тооцоог улирлын хэлбэлзлийг арилгасан, улирлын хэлбэлзэлтэй гэсэн 2 хувилбараар хийнэ.

Салбарын үндсэн үзүүлэлтийн хандлага, өөрчлөлтөд тулгуурлан ДНБ-ийг улирлаар тооцоход тооцооны гол хэрэгсэл болох Бенч<sup>2</sup> программыг, ДНБ-ий улирлын хэлбэлзлийг арилгаж тооцоход Х12-Арима<sup>1</sup> төрлийн программыг тус тус ашиглана.

## **ХОЁР. ДНБ-ИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, УЛИРЛААР, ОНЫ ҮНЭЭР ТООЦОХ АРГАЧЛАЛ**

### **Салбаруудын нэмэгдэл өртгийг оны үнээр тооцох нь.**

Эдийн засгийн салбаруудын нэмэгдэл өртгийг улирлаар тооцоход гол анхаарах зүйл бол салбаруудын онцлог болон тухайн салбарын үйл ажиллагааны гол шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, тусгах явдал юм.

### **2.2.1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар**

#### **2.2.1.1 Газар тариалан**

##### 1.Тооцох арга:

Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл нь жилийн турш үргэлжилж байдаг онцлогтой салбар юм. Иймээс салбарын улирлын нэмэгдэл өртгийг тооцохын тулд эхлээд тухайн жилийн нэмэгдэл өртгийг урьдчилсан байдлаар тооцно. Үүний тулд салбарын олон жилийн динамик үзүүлэлтийг ашиглан тухайн жилийн ургацын балансыг урьдчилан тооцно. Ургацын балансад үндэслэн “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-д тусгасны дагуу ургацын төрлүүдээр нийт үйлдвэрлэлтийн тооцоог гаргана. Жилийн турш явцын дунд урьдчилсан гүйцэтгэлийн тооцоог шинэчлэн тодотгол хийнэ.

Салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо улирал тус бүрийн нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч тооцно. Жилээр тооцсон нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээг улирлаар хувиарлахдаа тухайн улиралд гарах зардлуудын хувийн жинг ашиглана (Хүснэгт 2).

---

<sup>2</sup> Бенч программыг Канад улсын Статистикийн газар, Х12-Арима программыг АНУ-ын Тооллогын товчоо зохиосон. (Программын ашиглалтын талаар Хавсралт 1-ээс үзэх)

## Хүснэгт 2. Газар тариалангийн салбарын зардлын бүтэц, ажлын үе шатаар

	ХУВЬ			
	I улирал	II улирал	III улирал	IV улирал
	Хөрс боловсруулалт	Тариалалт	Ургац хураалт	Ургац хураалт, хөрс боловсруулалт
Цалин, холимог орлого	5.0	40.0	45.0	10.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	5.0	50.0	30.0	15.0
Үр	-	100.0	-	-
Бордоо	-	100.0	-	-
Хортон устгалт	-	100.0	-	-
Түлш, шатахуун	5.0	50.0	30.0	15.0
Сэлбэг хэрэгсэл	40.0	27.5	27.5	5.0
Бусад	25.0	25.0	25.0	25.0

Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээг улирлаар тооцох үндсэн арга нь:

- 1-рт, Ургацын баланс дээр үндэслэн нийт үйлдвэрлэлтийн хэмжээг гаргах.
- 2-рт, Урьд оны нийт үйлдвэрлэлтийн зардлын бүтцийг ашиглан зардлуудыг мөнгөн дүнгээр илэрхийлэх.
- 3-рт, Газар тариалангийн салбарын ажлын үе шатны улирлын зардлын бүтцийг ашиглан зардлуудыг улирлаар хувиарлаж, нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийг тооцож гаргах.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Салбарын тайлант оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээллийн эх үүсвэр нь “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн сарын мэдээ” ХАА-3, “Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан” ХАА-4, “Жимс, жимсгэний тариалсан талбай, хураасан ургацын мэдээ” ХАА-5, “Хадлан, тэжээл бэлтгэл, ургац хураалт” ХАА-7, “Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн тариалсан талбайн жилийн эцсийн мэдээ” ХАА-8, “Аж ахуйн нэгжийн (ХЭАА-гаас бусад) хураасан ургацын эцсийн мэдээ” ХАА-10а, “Өрх, хувиараа эрхлэх аж ахуйн хураасан ургацын эцсийн мэдээ” ХАА-10б маягт, ХХААЯ-ны захиргааны статистик мэдээллийн маягт “Уринш элдэншүүлэлтийн сарын мэдээ” зэрэг мэдээ, тайлан болон өмнөх оны нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээний зардлын бүтэц зэргийг ашиглана.

### **2.1.2 Мал аж ахуй**

#### 1.Тооцох арга:

Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо газар тариалангийн салбарын нэгэн адил жилийн нийт үйлдвэрлэлтийн тооцоог урьдчилан хийж, дараа нь улиралд хувиарлан тооцно. Мал болон тэжээвэр амьтдын тоог урьдчилан тооцсоны үндсэн дээр малын ашиг шимийн бүтээгдэхүүн, малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийг “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-д тусгасны дагуу тооцно. Нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо улирал тус бүрийн нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хасч тооцно.

Нийт үйлдвэрлэлт: Жилийн нийт үйлдвэрлэлтийг улиралд хувиарлахдаа малын ашиг шимийн бүтээгдэхүүн, малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлт тус бүрээр

улирлаар хувиарлана. Жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээг улирлаар хувиарлахдаа дараахь хувь хэмжээг мөрдлөг болгоно.

*Мах үйлдвэрлэлт:* Мах үйлдвэрлэлтийг улирлаар тооцохдоо махны хэрэглээ, мах үйлдвэрлэлтийн онцлогийг харгалзан дараахь хувийг ашиглана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Мах үйлдвэрлэлт	12%	13%	25%	50%

*Сүү үйлдвэрлэлт:* Манай орны мал аж ахуйн салбарын онцлогоос хамаарч сүү үйлдвэрлэлтийг улирлаар тооцохдоо дараахь хувийг ашиглана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Сүү үйлдвэрлэлт	5%	20%	50%	25%

*Ноос үйлдвэрлэлт:* Ноос үйлдвэрлэлтийн хувьд хонины ноосыг ихэвчлэн 7 дугаар сард, хониноос бусад малын ноос, ноолуурыг 4-6 сард хяргаж байгааг харгалзан ноос үйлдвэрлэлтийн хэмжээг улирлаар тооцоход дараахь хувийг ашиглана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Хонины ноос			100%	
Бусад		100%		

*Арьс үйлдвэрлэлт:* Арьс үйлдвэрлэлтийг мах үйлдвэрлэлтийн нэгэн адилаар дараахь хувиар тооцно.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Арьс үйлдвэрлэлт	12%	13%	25%	50%

*Шинээр нэмэгдсэн төл:* Шинээр нэмэгдсэн төлийн тоог мал төллөлтийн олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн дараахь хувиар тооцно.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Мал төллөлтийн хувь	26%	71%	3%	-

*Өндөг үйлдвэрлэлт:* Өндөг үйлдвэрлэлтийг өрхийн аж ахуйн хэрэглээг үндэслэж гаргана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Өндөгний хэрэглээ	22.2%	26.1%	26.3%	25.4%

*Бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт:* МАА-н салбарын бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг улирлаар тооцоход дараахь хувийг ашиглана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Том малын өсөлт	25%	25%	25%	25%
Амьтдын өсөлт	25%	25%	25%	25%
Зөгийн бал	-	-	100%	-
Бугын эвэр	-	100%	-	-
Үслэг арьс	50%	-	-	50%
Өтөг бууц, аргал, хөрзөн	25%	25%	25%	25%

*Завсрын хэрэглээ:* Мал аж ахуйн салбарын завсрын хэрэглээг улирлаар тооцоход малын тэжээлээс бусад зардлын хувьд ижил тэнцүүгээр, харин малын тэжээлийн хувьд бэлчээрийн мал аж ахуйтай учир эхний 2 улиралд хувиарлана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Малын тэжээл	50%	50%		
Бусад зардал	25%	25%	25%	25%

## 2.Мэдээллийн эх үүсвэр:

Салбарын тайлант оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээллийн эх үүсвэр нь тухайн жилийн малын урьдчилсан тоо, салбарын олон жилийн динамик үзүүлэлт, “Мал төллөлт, төл бойжилт” (ХАА-1), “Том малын зүй бус хорогдол” (ХАА-2), “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн сарын мэдээ” ХАА-3, “Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан” ХАА-4, нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээний зардлын улирлын бүтэц зэргийг ашиглана.

### **2.1.3 Ан агнуур, ойн аж ахуй, загас барилт**

#### 1.Тооцох арга:

Ан агнуур, ойн аж ахуй, загас барилт зэрэг салбарууд нь ДНБ-д бага хувийн жин эзэлдэг. Эдгээр салбарын нэмэгдэл өртгийг тооцохдоо салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан тооцно.

#### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Ан агнуурын үйл ажиллагааны жилийн тайлан АА-1, Ойн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн мэдээ ОАА-1, Загасны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны жилийн тайлан ЗАА-1 болон салбарын өмнөх онуудын нэмэгдэл өртгийн мэдээлэл нь мэдээллийн эх үүсвэр болно.

## **2.2. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарт дараахь 3 үндсэн дэд салбар багтана. Үүнд: Уул уурхай, олборлох аж үйлдвэр; боловсруулах аж үйлдвэр; цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж.

#### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Аж үйлдвэрийн салбарын үндсэн үзүүлэлт нь гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн хэмжээ байна. Улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг ерөнхий тооцооны аргын дагуу нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан тооцно.

#### 2.Мэдээллийн эх үүсвэр:

“Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ (АҮ-1)” маягтаар цуглуулсан мэдээлэлд үндэслэнэ.

## **2.3 Барилга**

#### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Барилгын салбарын улирлын үндсэн үзүүлэлт нь барилга угсралт, их засварын ажлын улирлын гүйцэтгэлийн хэмжээ байна. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

#### 2.Мэдээллийн эх үүсвэр:

“Барилга угсралт, их засварын ажлын улирлын мэдээ (ИБ-1)” маягтаар цуглуулсан мэдээлэлд үндэслэнэ.

## **2.4 Бөөний болон жижиглэнгийн худалдаа**

### 1. Салбарын үндсэн үзүүлэлт:

Дотоод худалдааны салбарт бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын нийт борлуулалт салбарын улирлын үндсэн үзүүлэлт болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2. Мэдээллийн эх үүсвэр.

“Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын улирлын мэдээ” (ХУ-1а) мэдээллийн эх үүсвэр болно.

## **2.5 Зочид буудал, зоогийн газар:**

### 1. Салбарын үндсэн үзүүлэлт:

Зочид буудал, зоогийн газрын салбарын нийт орлогын хэмжээ (*цаашид ажиллагчдын тоо*) салбарын улирлын үндсэн үзүүлэлт болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2. Мэдээллийн эх үүсвэр.

“Зочид буудлын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗБ-1)”, “Зоогийн газрын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗГ-1)” маягтуудаар мэдээллийг цуглуулна.

## **2.6 Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо:**

Тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар, дэд бүлэг тус бүрээр тооцно.

### 1. Салбарын үндсэн үзүүлэлт:

Тээврийн салбарт төмөр зам, агаарын тээвэр, авто болон усан замын тээвэр, тээврийн үйл ажиллагаатай холбоотой бусад туслах үйл ажиллагаа хамрагдана. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлтүүд нь оны үнийн тооцоонд тээврийн салбарын орлого байх бөгөөд тээврийн төрлөөр гарна. Холбооны салбарын хувьд мөн адил нийт орлогын хэмжээ нь салбарын үндсэн үзүүлэлт болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2. Мэдээллийн эх үүсвэр:

“Авто, усан замын тээврийн тээвэрлэлтийн улирлын мэдээ (Т-1)”, “Агаарын тээврийн тээвэрлэлтийн сарын мэдээ (АТ-7)”, “Төмөр замын тээвэрлэлтийн сарын мэдээ (АТ-9)”, “Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний улирлын тайлан (ШХИҮ-1)” мэдээллийн эх үүсвэр болно.

## **2.7 Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа:**

Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарт банк, банк бус санхүүгийн үйл ажиллагааны салбар, даатгалын салбар, бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа хамрагдана.

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Энэ салбарын гол дэд салбар нь банкны үйл ажиллагааны салбар, 2005 оны байдлаар салбартаа 86.1 хувийг эзэлж байна. Иймд, банкны үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаа гэсэн дэд салбараар тооцно. Тооцооны үндсэн арга нь бусад салбаруудын нэгэн адил нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн харьцааг ашиглан тооцно. Банкны үйл ажиллагааны салбарт шалгуур үзүүлэлт нь улирлын эцэс дэх зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ болон хадгаламжийн хэмжээ байна.

### 2.Мэдээллийн эх үүсвэр.

Монголбанкны “Статистикийн сарын бюллетень”, “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ БЗҮ-1а” (2007.08.08 №115), “Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны улирлын мэдээ ХЗХ-1” (2007.08.08 №115), “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ ББСБ-1” (2007.08.08 №115), “Даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны улирлын тайлан Д-2” (2007.01.09 №4) маягтуудаар цуглуулсан мэдээллийг ашиглана.

## **2.8 Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарт дараахь үйл ажиллагаа орно. Үүнд:

- үл хөдлөх хөрөнгөтэй холбогдох үйл ажиллагаа:
- машин, тоног төхөөрөмж, гэр ахуйн бараа түрээслэл
- компьютер, түүнд холбогдох үйл ажиллагаа
- эрдэм шинжилгээний ажил
- бизнесийн бусад үйлчилгээ

Салбарын нийт орлогын хэмжээ улирлын үндсэн үзүүлэлт болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцаагаар улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

“Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ” ЭШС-1 (2007.08.08 №114), Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, “Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зарлагын улирлын мэдээ” МЗ-1 (2000.03.21 №37), “Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан” ТББ-1 (2002.02.27 №37).

## **2.9 Төрийн удирдлага, албан журмын нийгмийн даатгал**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Энэ салбарын хувьд үндсэн үзүүлэлт нь улсын төсвөөс олгосон ажиллагчдын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцаагаар улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ мэдээллийн үндсэн эх үүсвэр болно.

## **2.10 Боловсролын үйл ажиллагаа**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Боловсролын салбарын хувьд дэд салбаруудаар, жигнэсэн индексийг ашиглан тооцно. Суурь боловсрол, бүрэн дунд боловсрол, дээд боловсрол, бусад боловсрол олгох үйл ажиллагаа гэсэн дэд салбаруудаар ангилдаг.

Энэ салбарын оны үнийн тооцооны үндсэн үзүүлэлт нь улсын төсвөөс олгосон ажиллагчдын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн BI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр.

Улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, “Мэргэжлийн түр сургалтын үйл ажиллагааны улирлын мэдээ” (2007.08.08 №113).

## **2.11 Эрүүл мэндийн үйл ажиллагаа**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Эрүүл мэндийн салбарт хүн эмнэлэг, мал эмнэлэг, нийгмийн халамжийн үйл ажиллагаа хамрагдана. Хүн эмнэлэг, нийгмийн халамжийн салбарын (төрийн) хувьд оны үнийн тооцоонд үндсэн үзүүлэлт нь улсын төсвөөс олгосон ажиллагчдын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, мал эмнэлгийн салбарт улирлын нийт орлогын үзүүлэлт байна. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн BI харьцаагаар улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын орлого, зарлагын улирлын, жилийн тайлан ЭМТ-6” (2007.06.11 №76), “Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын тайлан МЭ-1” (2007.07.23 №104)

## **2.12 Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Салбарын улирлын тооцооны үндсэн үзүүлэлт нь салбарын улирлын нийт орлого байна. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн BI харьцааг ашиглан улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

“Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан” ТББ-1 (2002.02.27 №37), “Үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирлын тайлан” ҮЗ-1 (2000.03.21 №37), “Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ” СБТ-1 (2007.08.08 №114), “Сүм, хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан” СХ-1 (2007.06.26 №92) маягт нь мэдээллийн эх үүсвэр болно.

## **2.13 Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Санхүүгийн шууд бус үйлчилгээний үзүүлэлтийн хувьд санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарын нэгэн адил зээлийн хүүгийн өрийн үлдэгдлийн хэмжээ болон хадгаламжийн хэмжээ нь улирлын үндсэн үзүүлэлт болно. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээний хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Монголбанкны Статистикийн сарын бюллетень мэдээллийн эх үүсвэр болно.

## **2.14 Бараа, үйлчилгээний татвар, татаас**

### 1.Салбарын үндсэн үзүүлэлт:

Улсын нэгдсэн төсвийн мэдээгээр бараа, үйлчилгээний татвар, татаасын хэмжээ сараар гардаг. Салбарын нэмэгдэл өртөг үйлдвэрлэлтийн ВI харьцааг ашиглан улирлын бараа, үйлчилгээний татвар, татаасын хэмжээг тооцно.

### 2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно.

## **ГУРАВ. ДНБ-ИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, УЛИРЛААР, ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГА ЗҮЙ**

Салбаруудын нэмэгдэл өртгийг улирлаар зэрэгцүүлэх үнээр тооцоход ҮСГ-ын дарга, Сангийн сайдын 2007 оны 7 сарын 9-ний өдрийн 101/203 тоот тушаалаар батлагдсан “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-ыг баримтална.

## **3.1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, загас барилтын салбар**

### **3.1.1 Газар тариалан**

Салбарын улирлын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо жилийн ургацын баланс буюу нийт үйлдвэрлэлтийг зэрэгцүүлэх үнээр тооцож, жилийн нийт үйлдвэрлэлтийн өсөлтийг олно. Өмнөх оны зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийн гүйцэтгэлийг нийт үйлдвэрлэлтийн өсөлтөөр үржүүлж, зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн хэмжээг тооцно. Оны үнийн тооцоонд ашигласан нэмэгдэл өртгийн улирлуудын хувийн жинг ашиглан зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийн хэмжээг улирлаар хувиарлана.

### **3.1.2 Мал аж ахуй**

Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийг улирлаар зэрэгцүүлэх үнээр тооцохдоо жилийн нэмэгдэл өртгийн гүйцэтгэлийг зэрэгцүүлэх үнээр урьдчилан тооцож, оны үнийн тооцооны нэгэн адил улиралд хувиарлана. Жилийн нэмэгдэл өртгийн гүйцэтгэлийг урьдчилан тооцохдоо өмнөх оны нэмэгдэл өртгийн гүйцэтгэлийг газар тариалангийн салбарын адил нийт үйлдвэрлэлтийн өсөлтөөр үржүүлж тооцно.

### **3.1.3 Ан агнуур, ойн аж ахуй, загас барилт**

Энэ салбарын хувьд өмнөх онуудын мэдээлэлд үндэслэн нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувийг ашиглан тооцож болно.

### **3.2. Аж үйлдвэр**

Салбарын улирлын зэрэгцүүлэх үнийн тооцоонд үндсэн үзүүлэлт нь гол нэр төрлийн бүтээгдэхүүний зэрэгцүүлэх үнээр үнэлсэн нийт үйлдвэрлэлтийн хэмжээ байна.

### **3.3 Барилга**

Барилгын салбарын оны үнээр, улирлаар тооцсон нэмэгдэл өртгийн хэмжээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн “орон сууцны урсгал засварын материал” бүлэг (04.2.1)-ийн улирлын дундаж индекс-д хувааж тооцно.

### **3.4 Бөөний болон жижиглэнгийн худалдаа**

Дотоод худалдааны салбарын оны үнээрх улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ ХҮИ-ийн барааны үнийн улирлын дундаж индекс”-д хувааж тооцно.

### **3.5 Зочид буудал, зоогийн газар**

Зочид буудал, зоогийн газрын салбарын оны үнээрх улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ ХҮИ-ийн ресторан, кафе, бусад зоогийн газар бүлэг (11.1.1) дэх рестораны хоолны үнийн улирлын дундаж индекс-д хувааж тооцно.

### **3.6 Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо**

Тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар, дэд бүлэг тус бүрээр тооцно.

#### **3.6.1 Тээвэр:**

Тээврийн салбар нь дотроо төмөр зам, агаарын тээвэр, авто болон усан замын тээвэр, тээврийн үйл ажиллагаатай холбоотой бусад туслах үйл ажиллагаа гэсэн дэд бүлгүүдтэй. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлтүүд нь тээврийн төрлүүдээр улирлаар гарах бөгөөд тээврийн салбарын нэмэгдэл өртгийг тооцоходоо салбарын суурь оны нэмэгдэл өртгийг түүнд салбаруудын эзлэх хувийн жингээр жигнэн тооцсон индексээр үржүүлнэ.

Тээврийн үйл ажиллагаатай холбоотой бусад туслах үйл ажиллагааны салбарын хувьд улирлын тооцоог хийхдээ нэмэгдэл өртгийн жилийн тооцоог өмнөх онуудын өсөлтийн хандлага дээр үндэслэн урьдчилан тооцно. Дараа нь улирлуудад тэнцүү хувиарлана. Жишээ: тээврийн салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцох.

1. Тээврийн салбарын ДНБ-ийг улирлаар тооцоход хэрэглэх үндсэн үзүүлэлт нь шилжүүлсэн тонн/км байна. Энэ үзүүлэлт нь тээврийн төрлүүдээр тооцогдоно.

**Хүснэгт 3. Төмөр замын тээврийн шилжүүлсэн тонн/км,  
2000-2006, сая тонн/км**

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
I улирал	400	551	637	665	772	889	917
II улирал	430	532	627	679	841	855	917
III улирал	457	526	672	695	856	957	824
IV улирал	562	592	675	811	969	888	878
<b>Дүн</b>	<b>1,850</b>	<b>2,202</b>	<b>2,612</b>	<b>2,850</b>	<b>3,438</b>	<b>3,589</b>	<b>3,536</b>
Улирлын дундаж	463	550	653	712	860	897	884

2. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлтийн суурь онтой харьцсан индексийг мөн тээврийн төрлүүдээр тооцно.

Индексийг улирлаар тооцохдоо суурь оны гүйцэтгэлд суурь оны улирлын дундаж үзүүлэлтийг авч хувааж тооцно.

Дараахь томъёог ашиглана.

$$I_{(t-1),i} = a_{(t-1),i} / \bar{a}_t \quad (2)$$

$I_{(t-1),i}$  – t суурь оноос өмнөх оны, i-р улирлын индекс

$a_{(t-1),i}$  – t-1 оны, i-р улирлын үндсэн үзүүлэлт

$\bar{a}_t$  – t суурь оны улирлын дундаж үзүүлэлт

**Хүснэгт 4. Төмөр замын тээврийн шилжүүлсэн тонн/км-ын  
2005 онтой харьцсан индекс**

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
I улирал	44.6	61.4	71.0	74.1	86.0	99.1	102.2
II улирал	48.0	59.3	69.9	75.7	93.7	95.3	102.2
III улирал	51.0	58.6	74.9	77.4	95.4	106.6	91.9
IV улирал	62.7	66.0	75.2	90.4	108.0	99.0	97.9
<b>Дүн</b>	<b>51.5</b>	<b>61.3</b>	<b>72.8</b>	<b>79.4</b>	<b>95.8</b>	<b>100.0</b>	<b>98.5</b>

хувь

3. Тээврийн салбарын дэд бүлгүүдийн суурь оны нэмэгдэл өртгийн хувийн жинг ашиглан тээврийн салбарын жигнэсэн индексийг дараахь томъёогоор тооцно.

$$I_{t-1,i}^* = \sum_{j=1}^4 I_{t-1,i}^j * b_j \quad (3)$$

$I_{t-1,i}^*$  – t суурь оноос өмнөх оны, i-р улирлын жигнэсэн индекс

$j$  – тээврийн салбарын дэд салбарууд

$b_j$  – j салбарын суурь оны нэмэгдэл өртгийн хувийн жин

4. Суурь оны нэмэгдэл өртгийн хэмжээг улирлын дээрх жигнэсэн индекс үржүүлж, улирлын үндсэн үзүүлэлтэд суурилсан нэмэгдэл өртгийн хэмжээг гаргана.

5. Аж үйлдвэрийн салбарын нэгэн адил улирлаар тооцсон нэмэгдэл өртгийг Бенч программыг ашиглан жилийн жинхэнэ гүйцэтгэлд уялдуулна.

### **3.6.2 Холбоо:**

Холбооны салбар нь тээврийн салбарын нэгэн адил голлох дэд салбаруудаар тооцогдоно. Улирлын шалгуур үзүүлэлтэд телефон утас, телеграфын үйл ажиллагааны дэд салбарт улирлын эцэс дэх суурин телефон цэгийн тоог, үүрэн телефоны үйл ажиллагааны дэд салбарт үүрэн телефон хэрэглэгчдийн тоог тус тус авна. Харин бусад гэсэн салбарын хувьд улирлын хэлбэлзэлгүй гэж үзэн оны гүйцэтгэлийг урьдчилан тооцож улирлуудад тэнцүү хуваана.

### **3.7 Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа**

Салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо оны үнээр тооцсон улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг ХҮИ-ийн “үйлчилгээний үнийн суурь онтой харьцсан улирлын дундаж индекс”-д хувааж тооцно.

### **3.8 Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа**

Салбарын нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо оны үнээр тооцсон улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг ХҮИ-ийн “үйлчилгээний үнийн суурь онтой харьцсан улирлын дундаж индекс”-д хувааж тооцно.

### **3.9 Төрийн удирдлага, албан журмын нийгмийн даатгал**

Энэ салбарын хувьд үндсэн үзүүлэлт нь ажиллагчдын тоо байна. Ажиллагчдын тооны суурь онтой харьцсан индекс, түүнд үндэслэн шалгуур үзүүлэлтээр салбарын нэмэгдэл өртгийг тооцно.

### **3.10 Боловсролын үйл ажиллагаа**

Боловсролын салбарын хувьд тээвэр, холбооны салбарын нэгэн адил дэд салбаруудаар, жигнэсэн индексийг ашиглан тооцно. Дараахь дэд салбаруудаар ангилна. Үүнд: Суурь боловсрол, бүрэн дунд боловсрол, дээд боловсрол олгох үйл ажиллагаа. Салбарын үндсэн үзүүлэлт нь сургуульд суралцагчдын тоо байна. Үндсэн үзүүлэлтийг улирлаар хувиарлахдаа тайлант оны 1-3 дугаар улиралд өмнөх хичээлийн шинэ жилийн суралцагчдын тоог, харин 4-р улиралд тайлант оны хичээлийн жилийн суралцагчдын тоо байна. Суурь боловсрол олгох үйл ажиллагааны салбарт “цэцэрлэгийн хүүхдийн тоо”, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааны салбарт “ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоо”, дээд боловсрол олгох үйл ажиллагааны салбарт “их, дээд сургуульд суралцагчдын тоо”- нь тооцооны үндсэн үзүүлэлт байна.

### **3.11 Эрүүл мэндийн үйл ажиллагаа**

Хүн эмнэлгийн салбарын хувьд үндсэн үзүүлэлт нь салбарын ажиллагчдын тоо байна. Салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ ажиллагчдын тооны өсөлтийг ашиглана. Мал эмнэлгийн салбарын зэрэгцүүлэх үнээрх улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцохдоо өмнөх оны нэмэгдэл өртгийн хэмжээг малын тоо толгойн жилийн өсөлтөөр үржүүлж 4-т хувааж тооцно.

### **3.12 Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ**

Салбарын оны үнээрх улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг ХҮИ-ийн “үйлчилгээний үнийн суурь онтой харьцсан улирлын дундаж индекс”-д хувааж тооцно.

### **3.13 Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ**

Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарын оны үнээрх улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг ХҮИ-ийн “үйлчилгээний үнийн суурь онтой харьцсан улирлын дундаж индекс”-д хувааж тооцно.

### **3.14 Бараа, үйлчилгээний татвар, татаас**

Бараа, үйлчилгээний татвар, татаасын хэмжээг улирлаар зэрэгцүүлэх үнээр тооцохдоо дотоодын архи, пиво, тамхи үйлдвэрлэлтийн хувьд салбарын улирлын нийт үйлдвэрлэлтийн суурь онтой харьцсан өсөлтөөр үржүүлж, харин бусад татвар, татаасын хувьд хэрэглээний үнийн улирлын дундаж ерөнхий индекс хувааж тооцно.

## **ДӨРӨВ. ДНБ-ИЙГ ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР, УЛИРЛААР ТООЦОХ АРГА ЗҮЙ**

### **4.1 ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцох арга зүй**

ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, улирлаар, оны үнээр тооцохдоо ҮСГ-ын дарга, Сангийн сайдын 2007 оны 7 сарын 9-ний өдрийн 101/203 тоот тушаалаар батлагдсан “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-ыг баримтална.

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь дотроо өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

#### **4.1.1 Эцсийн хэрэглээ**

Эцсийн хэрэглээ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээнээс бүрдэнэ. Эцсийн хэрэглээ нь эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий 70 орчим хувийг эзэлдэг гол бүрэлдэхүүн хэсэг юм.

#### **А. Өрхийн аж ахуйн хэрэглээ**

1. Тооцох арга. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны хүнсний хэрэглээ, хүнсний бус барааны худалдан авалтын дүнгээр нийт хэрэглээг тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь мэдээллийн эх үүсвэр болно.

## **Б. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ**

1. Тооцох арга. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг нийт үйлдвэрлэлт буюу төсөвт байгууллагын урсгал зардлын гүйцэтгэл, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын зөрүүгээр тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын гүйцэтгэлийг мэдээллийн эх үүсвэр болгож ашиглана.

## **В. Төрийн бус байгууллагын хэрэглээ**

1. Тооцох арга. Төрийн бус байгууллагын хэрэглээг урсгал зардлаар нь тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр. “Төрийн бус байгууллагын орлого, зарлагын улирлын тайлан” ТББ-1, “Сүм хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан” СХ-1 маягтаар авсан мэдээлэл болно.

### **4.1.2 Нийт хөрөнгийн хуримтлал**

Нийт хөрөнгийн хуримтлал нь үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалаас бүрддэг.

1.Тооцох арга: Нийт хөрөнгийн хуримтлалын мэдээллийг улирлаар тооцоход ихээхэн хүндрэлтэй байдаг. Өнөөгийн практикт хөрөнгийн хуримтлалыг улирлаар тооцох мэдээллийн эх үүсвэр хангалтгүй тул бусад мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглан тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр: Барилгын салбарын үйлдвэрлэлийн аргаарх улирлын тооцоо, гадаад худалдааны импортын мэдээлэл зэргийг ашиглана.

### **4.1.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт**

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-д бараа, үйлчилгээний гадаад худалдааны зөрүү буюу цэвэр экспортын дүнг тусгадаг ба энэ нь төлбөрийн тэнцэлтэй уялддаг.

1.Тооцох арга: Төлбөрийн тэнцэлд барааны экспорт, импортыг аль алиныг нь FOB нөхцөлийн үнээр үнэлж тусгах ёстой бөгөөд харин барааны импорт нь гаалийн статистикт СИФ нөхцөлийн үнээр үнэлэгдсэн байдаг. Иймээс төлбөрийн тэнцлийн статистикийн олон улсын стандартын дагуу импортын дүнгээс даатгал, тээврийн өртгийг салган үйлчилгээний бүлэгт шилжүүлэн импортыг FOB нөхцлөөр тооцож тусгана. Америк доллараар үнэлсэн бараа, үйлчилгээний гадаад худалдааны мэдээг тухайн улирлын америк доллартай харьцах төгрөгийн албан ёсны дундаж ханшаар бодож төгрөгт шилжүүлнэ.

2. Мэдээллийн эх үүсвэр: Монголбанкнаас эмхтгэн гаргадаг төлбөрийн тэнцлийн улирлын статистик мэдээлэл байна.

## **4.2 ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр тооцох нь**

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхдээ YCG-ын дарга, Сангийн сайдын 2007 оны 7 сарын 9-ний өдрийн 101/203 тоот тушаалаар батлагдсан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал”-д заасны дагуу эцсийн ашиглалтын бүрэлдэхүүн бүрийг холбогдох боломжит индексүүдэд хувааж тооцох зарчмыг баримтална.

## Бенч программ, түүний ашиглалт

Бенч программ нь улирлаар тооцсон ДНБ болон жилийн ДНБ-ий тооцоог хооронд нь уялдуулан нийцрүүлэх зорилгоор статистикт ашиглагддаг программ юм.

Улирлаар тооцсон ДНБ-ий тооцоо нь жилийн ДНБ-ий тооцоотой уялдаатай байна. Өөрөөр хэлбэл дөрвөн улирлын ДНБ-ий нийлбэр нь жилийн гүйцэтгэлтэй шууд тэнцэнэ. Жилээр гаргаж буй ДНБ-ий ихэнх мэдээллүүд улирлынхтай харьцуулахад илүү найдвартай эх үүсвэрт тулгуурласан байдаг. Тиймээс улирлын болон жилийн ДНБ-ий тооцооны уялдааг хангах үүднээс улирлын тооцоонд засварлалт хийхдээ жилийн дүнгээрх тоо мэдээллийг авч үзэх шаардлагатай.

Улирлын болон жилийн тоон мэдээллийг харьцуулж судалснаар мэдээллийн чанарыг эргэж харах боломжийг олгодог. Улирлын мэдээллийг ашиглан жилийн урьдчилсан гүйцэтгэлийг гаргаж болдог.

Улирлын болон жилийн ДНБ-ий тооцоог уялдуулахдаа хэд хэдэн аргыг ашигладаг.

1. Хамгийн энгийн арга бол тус тусад нь тооцсон улирлын ДНБ-ий нийлбэр дүн болон жилийн гүйцэтгэлийн тэнцүүлэх арга бөгөөд ингэхдээ дээрх 2 тооцооны зөрүүг улирлуудад ижил хэмжээгээр аль эсвэл пропорционалаар хувиарлах арга юм. Энэ тохиолдолд дараахь 2 томъёог ашиглана.

Хэлбэлзэлийн жигд тархалт:

$$Y_{t,q} = X_{t,q} + \frac{1}{4} \left( A_{t,q} - \sum_{q=1}^4 X_{t,q} \right) \quad (4)$$

Хазайлтын пропорциональ тархалт:

$$Y_{t,q} = X_{t,q} \left( \frac{A_t}{\sum_{q=1}^4 X_{t,q}} \right) \quad (5)$$

Энд,

$Y_{t,q}$  - t жилийн q дүгээр улирлын харилцан уялдуулсан (шинэчилсэн) ДНБ

$X_{t,q}$  - t жилийн q дүгээр улирлын харилцан уялдаагүй өгөгдсөн ДНБ

$A_t$  - t шууд тооцсон жилийн ДНБ

Дээрх энгийн тархаалтын үед цуваанд нэг оны 4-р улирлаас дараагийн оны 1-р улиралд шилжихэд тодорхой хэмжээний үсрэлт гардаг дутагдалтай.

2. Эгнээний үсрэлтийг арилгах арга.

Эгнээний үсрэлтийг арилгах олон арга байдаг. ОУВС-ийн “Улирлын үндэсний тооцооны гарын авлагад зөвлөмж болгосон нь Дентоны хамгийн бага квадратын арга юм. Энэ арга нь улирлын тооцооны үзүүлэлтүүдийн нийлбэр нь жилийн дүнтэйгээ тэнцүү байна гэж үзэж, улирлын засварласан үзүүлэлт болон улирлын анхдагч үндсэн үзүүлэлтийн ялгаврын квадрат нь хамгийн бага байх нөхцөлөөр цувааны үсрэлтийг арилгах арга.

## Бенч программыг ашиглах жишээ

Улирлын мэдээллийг жилийн мэдээлэлтэй уялдуулдаг Бенч программыг Канадын статистикийн газраас зохиож гаргасан байдаг. Энэ программ нь Дентоны арга техникт суурилсан. Сар, улирлын мэдээллийг жилийн мэдээлэлтэй уялдуулах, хэтийн төлөвийг тодорхойлоход энэхүү программыг ашигладаг.

Бенч программын ажиллах зарчмыг тодорхой болгох, түүнийг ашиглан салбарын улирлын нэмэгдэл өртөг тооцох жишээг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын жишээгээр авч үзье.

Жишээ: Бенч программ ашиглаж, улирлын үндсэн үзүүлэлтүүд дээр суурилан улирлын нэмэгдэл өртгийг тооцох.

Үүнд дараахь мэдээлэл шаардлагатай:

- а. салбарын жилийн жинхэнэ гүйцэтгэл
- б. салбарын улирлын үндсэн үзүүлэлтүүд.

1. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын 2000-2006 оны **нэмэгдэл өртөг**, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг.

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Нэмэгдэл өртөг</b>	<b>416.2</b>	<b>453.7</b>	<b>416.3</b>	<b>408.3</b>	<b>548.3</b>	<b>608.2</b>	<b>646.3</b>

2. Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын 2000-2006 оны **НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ**, улирлаар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төг.

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
I улирал	130.5	130.7	167.3	143.1	142.5	187.0	181.7
II улирал	170.7	183.3	191.4	184.8	248.2	243.9	222.7
III улирал	217.0	243.9	209.6	221.8	262.1	278.9	231.0
IV улирал	189.5	242.4	221.9	191.0	191.9	226.0	318.4
<b>Нийт үйлдвэрлэлт</b>	<b>707.7</b>	<b>800.3</b>	<b>790.2</b>	<b>740.7</b>	<b>844.7</b>	<b>935.8</b>	<b>953.8</b>

3. Бенч программыг ашиглаж тооцсон Уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын 2000-2006 оны нэмэгдэл өртөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, улирлаар, тэрбум төг.

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
I улирал	77.1	75.9	90.2	75.2	87.9	122.3	121.0
II улирал	100.7	105.4	101.1	99.1	160.2	157.4	150.1
III улирал	127.6	138.1	109.4	122.9	173.2	181.2	156.9
IV улирал	110.8	134.3	115.6	111.1	127.0	146.4	218.2
<b>Нэмэгдэл өртөг</b>	<b>416.2</b>	<b>453.7</b>	<b>416.3</b>	<b>408.3</b>	<b>548.3</b>	<b>608.2</b>	<b>646.3</b>

## Улирлын тооцоонд ашиглах мэдээлэл

## 1. Үйлдвэрлэлийн аргын тооцоо:

дд	Салбар	Үндсэн үзүүлэлт		Мэдээллийн эх үүсвэр
		Оны үнийн тооцоонд	Зэрэгцүүлэх үнийн тооцоонд	
1	Газар тариалан	Ургацын баланс, оны үнээр	Ургацын баланс, зэрэгцүүлэх үнээр	
2	Мал аж ахуй	Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт, оны үнээр	Мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлт, зэрэгцүүлэх үнээр	
3	Уул уурхай, олборлох үйлдвэр	Уул уурхай, олборлох үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, оны үнээр	Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, зэрэгцүүлэх үнээр	Сар, улирлын статистикийн бюллетень
4	Боловсруулах аж үйлдвэр	Боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, оны үнээр	Боловсруулах аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, зэрэгцүүлэх үнээр	Сар, улирлын статистикийн бюллетень
5	Цахилгаан эрчим хүч, усан хангамж	Цахилгаан, дулааны эрчим хүчний салбарын нийт үйлдвэрлэлт, оны үнээр	Цахилгаан, дулааны эрчим хүчний салбарын нийт бүтээгдэхүүн, зэрэгцүүлэх үнээр	Сар, улирлын статистикийн бюллетень
6	Барилга	Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, оны үнээр		Сар, улирлын статистикийн бюллетень
7	Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт, оны үнээр		Сар, улирлын статистикийн бюллетень
8	Зочид буудал, зоогийн газар	Зочид буудлын орлого, оны үнээр Зоогийн газар эрхэлдэг ААНБ-ын орлого, оны үнээр		Сар, улирлын статистикийн бюллетень
9	Тээвэр, холбоо	Тээврийн орлого, оны үнээр; Шуудан холбооны орлого, оны үнээр	Шилжүүлсэн сая тн.км, тээврийн төрлөөр; Суурин телефон цэгийн тоо, улирлын эцэст; Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо, улирлын эцэст	Сар, улирлын статистикийн бюллетень
10	Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст		Сар, улирлын статистикийн бюллетень
11	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	Салбарын орлогын хэмжээ, оны үнээр		

12	Төрийн удирдлага, албан журмын нийгмийн даатгал	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн зарлагын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, оны үнээр	Ажиллагчдын тоо	Сар, улирлын статистикийн бюллетень
13	Боловсрол	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн зарлагын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, оны үнээр		Сар, улирлын статистикийн бюллетень
14	Эрүүл мэнд	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн зарлагын цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, оны үнээр	Ажиллагчдын тоо	Сар, улирлын статистикийн бюллетень
15	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	Салбарын орлогын хэмжээ, оны үнээр		
16	Санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ	Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст		Сар, улирлын статистикийн бюллетень
17	Бараа, үйлчилгээний татвар, татаас	Улсын нэгдсэн төсвийн тайлан		Сар, улирлын статистикийн бюллетень

## 2. Эцсийн ашиглалтын аргын тооцоо:

Дд	Бүрэлдэхүүн	Мэдээллийн эх үүсвэр	Тайлбар
1	Хувийн хэрэглээ	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	
2	Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ	Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын тайлан	Сар, улирлын бюллетенд гардаг үзүүлэлт
3	Төрийн бус байгууллагын хэрэглээ	“Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан”, “Үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн орлого, зардлын улирлын тайлан”, “Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зарлагын улирлын мэдээ”, “Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ”, “Сүм, хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан.	
4	Нийт хөрөнгийн хуримтлал	Барилгын салбарын үйлдвэрлэлийн аргаарх улирлын тооцоо, гадаад худалдааны импортын мэдээлэл	
5	Бараа, үйлчилгээний цэвэр экспорт	Монгол банкнаас эмхтгэн гаргадаг төлбөрийн тэнцлийн улирлын статистик мэдээлэл	Сар, улирлын бюллетенд гардаг үзүүлэлт